



БАГАНУУР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 оны 04 дүгээр сарын 30

Багануур дүүрэг

Д/д	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах нэгж
1	АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ИРГЭДЭД СУРТАЛЧИЛАХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД				
	1.1.Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, гарын авлага, цахим номыг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэргээр олон нийтэд сурталчилж байх	Баримтжуулсан байх. Үр дүнг тооцож, тайлагнасан байх. (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо)	Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн 3 төрлийн шторк, мэдээлэл, видеог байгууллагын цахим хуудас, албан хаагчдын фэйсбүүк группэд байршуулан мэдээлэл түгээсэн нь 46 хариу үйлдэл, 14 хуваалцал, 356 хандалттай байна.	I-IV улиралд	ЗХХ
	1.2.Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг салбарын онцлогт тохируулан зохион байгуулах	2-оос доошгүй өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагаа, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байх. Үр дүнг тооцож, нотломжийг хавсаргасан байх.	Улсын Их Хурлын сонгууль болохтой холбогдуулан Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтад улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх зарчим, 39 дүгээр зүйлд заасан үйл ажиллагаа явуулахыг хориглох заалт, 49 дүгээр зүйлийн хориглох зүйлс зэргийг танилцуулж, хууль зөрчсөн		

		үйлдэл гаргахгүй байхыг анхааруулсан.		
	Өөрсдийн байгууллагын үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий контент бүтээж, олон нийтэд хүргэсэн байх	Нийгмийн даатгалын лого, нэр бүхий "Авлигын эсрэг аянд нэгдэе" сэдэвт контентыг бүтээж 2024 онд тус газрын фэйсбүүк хаяг, пэйжээр олон нийтэд түгээж сурталчилав.		
1.3 Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчилах, "Шударга ёс, хөгжил дэвшилд-110" мэдээллийн самбарын мэдээллийг тухай бүр шинэчилж, тогтмол ажиллуулах	Мэдээллийг сар бүр шинэчлэх. Тайланд сар бүр шинэчилсэн нотломжийг хавсаргасан байх.	Газрын мэдээллийн самбарт "Авлигын эсрэг нэгдье 110 дугаар залга" зурагт хуудсыг А4 хэмжээтэй хэвлэж, байрлуулсан. Мөн самбарт авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар гомдол мэдээлэл хүлээн авах эрх бүхий албан тушаалтны мэдээлэл бүхий зурагт хуудсыг зэрэгцүүлэн байршуулсан.	I-IV улиралд	ЗХХ
1.4 Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчид болон бусад нийт албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад бүрэн хамруулсан байх.	Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчид болон бусад нийт албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад бүрэн хамруулсан байх.	АТГ-аас зохион байгуулсан 2 удаагийн сургалтад давхардсан тоогоор төрийн захиргааны 23 албан хаагчийг оролцуулсан бол тус газраас зохион байгуулсан 3, НДЕГ-аас зохион байгуулсан 1 удаагийн сургалтад ЭБАТ оролцож, мэдээлэл авч түгээлээ.	I-IV улиралд	ЗХХ
1.5 Эрүүл мэндийн магадлалтай холбоотой хууль тогтоомжийг танилцуулах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах	Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Эрүүл мэндийн магадлалын төв болон салбар зөвлөлийн эмч, мэргэжилтнүүдэд 2-оос доошгүй удаагийн сургалт зохион байгуулсан байна.	АТГ, НДЕГ-аас 2024 оны 5 дугаар сард хамтран зохион байгуулсан "Авлигын шалтгаан нөхцөл, хор хөнөөл, гэмт хэрэг түүнээс урьдчилан сэргийлэх нь" сургалтад тус газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн 10 гишүүн 100%-ийн бүрэлдэхүүнтэй оролцож, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа тогтоох үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцдаа авлига, ашиг сонирхлын зөрчлөөс хэрхэн ангид байх, урьдчилсан сэргийлэх талаарх мэдлэг, мэдээллийг авсан.	I-IV улиралд	Тус дүүргийн ЭММЗ
1.6 Эрх бүхий байгууллагаас ирүүлсэн	Эрх бүхий байгууллагаас	НДЕГ-ын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны	I-IV улиралд	ЗХХ

дүрэм журмын төслийг судлан, санал хүргүүлэх	ирүүлсэн дүрэм, журмын төсөлд санал өгч ажилласан байна.	өдрийн 01/2353 дугаар албан бичиг, Авлигатай тэмцэх газрын 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 05/17686 дугаар албан бичгээр Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар тогтоолын 10 дугаар хавсралтаар баталсан “Мэдүүлэг гаргах албан хаагчийн жагсаалт”-д нэмэлт, өөрчлөлт оруулах санал авах хүсэлтийн дагуу тус нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрхтэй ТЗ-7 зэрэглэлээр цалинждаг, албан тушаалын тодорхойлолт нь ТЗ-8, ТЗ-9-өөр батлагдсан албан хаагчдыг “Мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалт”-д оруулах санал хүргүүлэв.		
1.7 Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар албан хаагч, олон нийтэд сурталчилах.	Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор албан хаагч, олон нийтэд мэдээлэл өгөх, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар таниулсан байна.		I-IV улиралд	ЗХХ
1.8 Хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг магадлан шийдвэрлэх үйл явцад гарсан аливаа хууль бус үйлдэл, зөрчил, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлэх.	Магадлагч эмч, мэргэжилтний гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг магадлан шийдвэрлэх үйл явцад гарсан аливаа хууль бус үйлдэл, зөрчил, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлэх арга хэмжээг тусгах. Хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг магадлан шийдвэрлэх үйл явцад авлига, ашиг сонирхлын зөрчлийг үл тэвчих, хяналт тавих боломж тавих.	Тайлант хугацаанд эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүний өөрийнх нь, дотрын эмчийн дүүгийн хөдөлмөрийн чадвар алдалтыг сунгах тохиолдол гарч, эдгээр гишүүд ашиг сонирхлын зөрчил үүсч байгаа тухайгаа зохих ёсоор мэдэгдэж, тухайн шийдвэрт тэдгээр гишүүд оролцоогүй.	I-IV улиралд	ЭММЗ

ИЛ ТОД БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ ХҮНД СУРТАЛ, ЧИРЭГДЭЛ БУУРУУЛАХ, ОЛОН НИЙТИЙН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД					
2	2.1.Нийгмийн даатгалын байгууллага болон хувийн хэвшлийн байгууллага хооронд байгуулж буй аливаа гэрээ, хэлэлцээрт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар зохицуулалт тусгах.	Гэрээ хэлэлцээрт авлигаас ангид байх, мэдээлэх, үүргийг тусгасан байх.	Гэрээ хэлэлцээрт авлигаас ангид байх, мэдээлэх, үүргийг тусгасан байх.	I-IV улиралд	СБХОХ
	2.2 Олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг тухай бүр цахим системд нээлттэй байршуулж, байгууллагын мэдээллийн ил тод, нээлттэй байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.	Олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор хуульд заасан мэдээллийг тухай бүр цахим системд нээлттэй байршуулах. Хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж гаргах.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны “Нээлттэй өгөгдөл, байршуулах төлөвлөгөө, хуваарь батлах тухай” А/20 дугаар тушаалын хавсралтаар Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 дахь хэсэгт заасан 66 төрлийн мэдээллийг байгууллагын цахим хуудсанд хуулийн хугацаанд байршуулж, байгууллагын шинээр батлагдсан бүтэц, орон тооны мэдээлэл, албан тушаалын тодорхойлолт, сул орон тооны зар зэрэг цаг үеийн шинжтэй 7 мэдээг 2024 оны 08 дугаар сард нэмж мэдээлэв. Baganuur.ndaatgal.mn сайтад оруулсан мэдээллийг shilen.gov.mn сайтад холбоос хаягаар байршуулж, байгууллагын үйл ажиллагааны 139, нийгмийн даатгалын сангийн 138 мэдээллийг хуулийн хугацаанд оруулан зөрчилгүй ажиллаж байна. Тус газар нь 2024 оны 02 дугаар улирлын байдлаар shilen.gov.mn сайтад байршуулсан мэдээллийн хяналт, үр дүнгээр 96%-ийн үнэлгээ авч “Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээний ТОП 10 байгууллага”-ын 7 дугаар байрт жагссан. 2024 оны 4 дүгээр улирлын мэдээг 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор бүрэн байршууллаа.	I-IV улиралд	ЗХХ

	2.3 Төсвийн орлого, зарлагын мэдээллийг эдийн засгийн болон зориулалтын ангиллаар олон нийтэд ил тод байршуулах, төсвийн ерөнхийлэн захирагч, шууд захирагч нарын ерөнхий мэдээллийг байгууллага тус бүрээр албан тушаал, нэрээр ил тод тодорхой болгох, албан тушаал, нэрээр ил тод тодорхой мэдээлэх.	Төсвийн орлого, зарлагын мэдээллийг эдийн засгийн болон зориулалтын ангиллаар олон нийтэд ил тод байршуулах, төсвийн ерөнхийлэн захирагч, шууд захирагч нарын ерөнхий мэдээллийг байгууллага тус бүрээр албан тушаал, нэрээр ил тод тодорхой болгох, албан тушаал, нэрээр ил тод тодорхой мэдээлсэн байна.	Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдлөг болгон 2024 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар үйл ажиллагааны зардалд 831,892.3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 786,026.4 мянган төгрөгийг хөтөлбөр, арга хэмжээнд тусгасан эдийн засгийн ангилал, зориулалтын дагуу зарцууллаа. Энэ нь тайлант үеийн төсвийн 94,48 хувийг эзэлж байна. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн "Төлөвлөгөө хэрэгжүүлэн ажиллах тухай" 01/2294 дүгээр албан бичгийн хүрээнд хавсралтаар ирүүлсэн постерт байгууллагын болон томилох эрх бүхий албан тушаалтан, эрх бүхий албан тушаалтны мэдээллийг оруулж, хэвлэн мэдээллийн самбарт байршуулж, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэх нөхцлийг, иргэд, даатгуулагчдад бүрдүүлсэн. Энэ төрлийн гомдол, мэдээлэл ирүүлээгүй байна.	I-IV улиралд	ЗХХ
	2.4 Маргаан хянан шийдвэрлэх зөвлөл, Ёс зүйн дэд хороо, Эрүүл мэндийн магадлалын зөвлөлд ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээлэл, маргаан таслах үйл ажиллагааг сайжруулах, өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэх.	Маргаан шийдвэрлэх хугацаа буурсан байна.	Тус газрын дэргэдэх Маргаан хянан шийдвэрлэх салбар зөвлөл (МХШСЗ), Эрүүл мэндийн магадлалын зөвлөл (ЭММЗ)-ийн гишүүд хуралд оролцох бүрд зөрчил үүссэн бол мэдэгдлийн маягтыг бөглөж, гарын үсэг зурж баталгаажуулж хэвшсэн. Тайлант хугацаанд ЭММЗ 36 удаа хуралдаж 902 иргэний, МХШСЗ 3 удаа хуралдаж 8 иргэний хүсэлтийг хэлэлцэн шийдвэрлэсэн байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль батлагдсантай холбоотой ёс зүйн дэд хорооны гишүүдийг хамт олны санал хураалтаар сонгож, хэлтсийн даргын 2023 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн А/15 дугаар тушаалаар ёс зүйн дэд хороог	I-IV улиралд	МХШСЗ ЁЗДХ ЭММСЗ

			байгуулан ажиллаж байна. Ёс зүйн дэд хороо даатгуулагчийн гаргасан гомдлын дагуу хуралдаж, гомдлыг хэлэлцээд холбогдох нэр бүхий 2 байцаагчийг "Ёс зүйн зөрчил гаргаагүй" дүгнэлт гаргав. Хурлаас гарсан дүгнэлтэд тусгасны дагуу нийт ажилтан, албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан төрийн албан хаагчийн ёс зүйн зарчмыг баримталж, нийтлэг хэм хэмжээг сахин мөрдөж, харилцаа хандлага, биеэ зөв боловсон авч явах, бусдад хүндэтгэлтэй хандаж төрийн албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэн өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллахыг зөвлөв.		
	2.5 Нийгмийн даатгалын цахим үйлчилгээг өргөжүүлэх замаар албан тушаалтнаас хамаарах нөлөөллийг багасгах, эрсдэлд өртөх магадлал, боломжийг бууруулах.	Олон хүүхэдтэй эхийн нөхцлөөр тогтоох өндөр насны тэтгэвэр, өндөр насны тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийг цахимаар хүсэлт гаргах, тогтоох, олгох бэлтгэл ажил хангагдсан байна. Нийгмийн даатгалын цахим системд тухай бүр хөгжүүлэлт хийгдсэн байна.	Нийгмийн даатгалын цахим үйлчилгээг өргөжүүлэх замаар албан тушаалтнаас хамаарах нөлөөллийг багасгах, эрсдэлд өртөх магадлал, боломжийг бууруулах арга хэмжээний хүрээнд шинэчилсэн Мэдээллийн нэгдсэн системийг ашиглаж байна. Тус систем нь орчин үеийн дэвшилтэт технологид суурилсан, уян хатан, динамик суурьтай, бодит цагийн горимд ажиллах "SICOS", мөн иргэд даатгуулагч, ажил олгогчдод зориулсан "Иргэний болон ажил олгогчийн портал системийг нэвтрүүлж байна.	I-IV улиралд	Дүүргийн НДГ
3	АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ ҮҮСЭХ, ШАЛТГААН НӨХЦӨЛИЙГ АРИЛГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ АВАХ ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД				
	3.1 Тухайн жилд Нийгмийн даатгалын байгууллагаас авлига, ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай эрх бүхий байгууллагаас шаардлага хүргүүлсэн, ашиг сонирхлын зөрчил үүсгэсэн, үүссэн байж болзошгүй тохиолдолд зөрчлийг таслан зогсоох	Нийгмийн даатгалын байгууллагаас авлига, ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай эрх бүхий байгууллагаас шаардлага хүргүүлсэн, ашиг сонирхлын зөрчил үүсгэсэн, үүссэн	Тайлант хугацаанд энэ төрлийн тохиолдол гараагүй.	I-IV улиралд	ЗХХ

	арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах.	байж болзошгүй тохиолдолд зөрчил гаргасан нэгж, ажилтанд тухайлан арга хэмжээ авах, гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилган, эрх бүхий байгууллагад тайлагнасан байна. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цахим орчин дахь нийгмийн даатгалын байгууллагын авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой, олон нийтийн анхаарал татсан мэдээллийн мөрөөр хуульд заасан арга хэмжээ авсан байх.			
	3.2 Шударга байдлын үнэлгээг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх ажиллах.	Нийгмийн даатгалын байгууллагын “Шударга байдлын үнэлгээ”-г 80 хувьд хүргэсэн байна.	Газрын даргын зүгээс Нийгмийн даатгалын ерөнхий газрын удирдах ажилтнуудын зөвлөгөөний үеэр танилцуулагдсан мэдээлэл, сургалт, лекцийн хүрээнд нийт албан хаагчдад мэдээлэл түгээх сургалтыг зохион байгуулсан. Уг сургалтын үеэр АТГ-аас өгсөн мэдээлэлд дурдсан “Төрийн байгууллагын 2023 оны шударга байдлын үнэлгээ”-гээр агентлагийн хэмжээнд 71 дүгээр байрт үнэлэгдсэн нь үнэлгээнд оролцогч албан хаагч, үйлчлүүлэгч, оролцогчдын зүгээс салбарын хэмжээнд авлига, ашиг сонирхлын зөрчил байна гэж үзэж байгаа талаар дурдаж, энэ үнэлгээг сайжруулахад авлига, ашиг сонирхлын аливаа төрлийн зөрчил гаргалгүй ажиллаж, иргэд, даатгуулагчдын итгэл үнэмшлийг дээшлүүлэхэд албан хаагч бүрийн оролцоо чухлыг сануулж, дор бүрнээ авлигын эсрэг нэгдэж ажиллахыг уриалав.	I-IV улиралд	Дүүргийн НДГ
	3.4 Төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэр, журам, дүрэм нь авлига, ашиг сонирхлын	Төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэр, журам, дүрэм нь	Тайлант хугацаанд энэ төрлийн тохиолдол гараагүй.	Тухай бүр	Дүүргийн НДГ

	зөрчил гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзвэл төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, журам, дүрмийг хянаж, хүчингүй болгуулах санал хүргүүлэх, өөрийн байгууллагын гаргасан тушаал шийдвэрт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох.	авлига, ашиг сонирхлын зөрчил гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзвэл төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, журам, дүрмийг хянаж, хүчингүй болгуулах санал хүргүүлэх, өөрийн байгууллагын гаргасан тушаал шийдвэрт өөрчлөлт оруулж хүчингүй болгосон байна. Шийдвэр, дүрэм, журам хүчингүй болгосон талаарх хүргүүлсэн санал, нотолгоог хүргүүлсэн байна.			
--	---	---	--	--	--

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:
ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

 Г.БАТБОЛД